



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/236

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/132 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсэгт "Хөвсгөл аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо" НҮТББ (1029959)-д эзэмшүүлсэн Мөрөн сумын 8 дугаар баг Дамдинбазар-2, 203 тоотод байршилтай 6712017296 нэгж талбарын дугаар бүхий үйлдвэрлэлийн зориулалттай 1696м2 газрыг иргэн Мянгад овгийн Батмөнхийн Анар-Эрдэнэ (РЭ89091719)-д үлдсэн 20 жилийн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/132 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болгосугай.


3. Захирамжаар газар эзэмшигч иргэн Батмөнх овогтой Анар-Эрдэнэд газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвцөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010113